

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН 2018 ОНЫ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

## Агуулга

|       |  |    |
|-------|--|----|
| 1     | Аудитын гэрчилгээ.....   | 2  |
| 2     | Аудитын тайлан.....  | 4  |
| 2.1   | Оршил.....   | 4  |
| 2.2   | Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....   | 4  |
| 2.3   | Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....  | 5  |
| 2.4   | Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....  | 5  |
| 2.5   | Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ..... | 6  |
| 2.6   | Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....   | 6  |
| 2.7   | Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....  | 6  |
| 2.8   | Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....   | 7  |
| 2.8.1 | Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал .....                                  | 7  |
| 2.9   | Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал....                                   | 8  |
| 2.10  | Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....   | 8  |
| 2.11  | Шилэн дансны мэдээлэл.....   | 8  |
| 2.12  | Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....  | 8  |
| 2.13  | Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....   | 9  |
| 3     | Менежментийн захидал.....  | 10 |
| 4     | Аудит хийгдсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан.....   | 11 |
| 4.1   | Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....  | 11 |
| 4.2   | Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....   | 12 |
| 4.3   | Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....   | 14 |
| 4.4   | Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....  | 16 |
| 4.5   | Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....  | 17 |
| 4.6   | Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....   | 19 |
| 5     | Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....  | 20 |

## Товчилсон үгийн жагсаалт

|          |   |
|----------|---|
| УСНББОУС | Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт |
| АДБОУС   | Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт               |
| АОУС     | Аудитын олон улсын стандарт                                 |



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:62-26-32-30  
E-mail: info@audit.gov.mn

2019.02.25 № 06/327  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Монголын театрын музейн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Монголын театрын музейн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Монголын театрын музейн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## 2 Аудитын тайлан

### 2.1 Оршил

Театрын музейн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг захирлын үүрэг гүйцэтгэгч Д.Наранжаргал танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

### 2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Голден пэйж Аудит ХХК нь Театрын музейн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд Үндэсний аудитын газартай байгуулсан гурвалсан гэрээг үндэслэн санхүүгийн тайлангийн аудитыг хийж гүйцэтгэлээ.

Театрын музейн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 1 дүгээр сарын 27-ноос 2019 оны 2 дугаар сарын 20-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 2 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Голден пэйж аудит ХХК-ийн захирал С.Оюунгэрэл хянан удирдаж, менежер Н.Очирмаа анхан шатны чанарын хяналтыг хийж, аудитор Б.Одгэрэл, аудиторовын туслах Б.Ариунтуяа нар хариуцаж хэрэгжүүлэв.

Театрын музей 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Санхүүгийн аудитын газарт 2019 оны 1 дүгээр сарын 24-ны өдрийн 08 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

## 2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

## 2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Театрын музейн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Театрын музей нь 2025 он гэхэд Монголын соёл урлаг, 3D үзүүлэлтийн тэргүүлэх чиглэлийн музей болох гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.4-д Театрын музейн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- музей нь тухайн нутаг дэвсгэрт орших соёлын өвийг бүртгэх, цуглуулах, хадгалж хамгаалах, судлах, сурталчлах чиг үүрэг бүхий соёл, эрдэм шинжилгээний байгууллага байна.

Театрын музейн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Театрын музейн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль

- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Соёлын тухай хууль
- Соёлын өвийг хамгаалах тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна.

## **2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Театрын музейн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Театрын музей санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Acolous” програм хангамж ашигладаг байна.

Театрын музейн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

## **2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад Театрын музейн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 6 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 6 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## **2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгов.

Нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь өмнөх оны аудитад материаллаг байдлыг тооцохдоо нийт зардлыг суурь үзүүлэлтээр сонгосон, мөн нийт болон цэвэр хөрөнгийн дүн өндөр байгаатай холбоотой юм.

Театрын музейн 2018 оны нийт зардал 178,688.73 мянган төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 3,573.77 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 2 хувиар тооцсон нь өмнөх оны аудитад материаллаг байдлын түвшинг нийт зардлын 2 хувиар тооцсон, тухайн байгууллагын хувьд эрсдэл бага гэж үзсэнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг В201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

## 2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 6 чиглэлээр аудитын 6 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 3 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, баталгаажууллаа.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

| /мянган төгрөгөөр/ |                         |     |         |         |
|--------------------|-------------------------|-----|---------|---------|
| №                  | Шийдэл                  | Тоо | Дүн     | Тайлбар |
| 1                  | Зөвлөмж өгсөн           | 1   | 1,000.0 |         |
| 2                  | Төлбөрийн акт тогтоосон | 2   | 1,958.7 |         |
|                    | Дүн                     | 3   | 2,958.7 |         |

### 2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх 3 асуудлыг менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

#### 2.8.1.1 Орлогын талаар

Төлбөртэй үйлчилгээний орлогыг бүртгэлд тусгаж тайлагнаагүй. Музейн Захирлын 2018 оны 5 дугаар сарын 23-ны А/13 тоот тушаалаар Монголын гэрэл зурагчдын холбоотой хамтарсан “Бугат бадигар сүм” үзэсгэлэн 3 хоног зохион байгуулсны орлого болох 300.0 мянган төгрөгөөр тасалбар хэвлүүлэх тушаал гарсан боловч уг орлого болон хөрөнгийг бүртгэлд тусгаж тайлагнаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Бүртгээгүй үйлчилгээний орлого болох 300.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэлээ.

### **2.8.1.2 Хариуцлагын талаар**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитын актын төлбөр 1,658.7 мянган төгрөгийг цалингийн зардлын сангаас гаргаж төлсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Цалингийн зардлаас гаргасан өмнөх актын төлбөр болох 1,658.7 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэлээ.

### **2.9 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Дараагийн аудитаар музейн орлогын талаарх асуудлыг нарийвчлан шалгах нь зүйтэй гэж үзлээ.

### **2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Театрын музейн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 1 хөтөлбөр, 5 арга хэмжээнд зориулан 2018 онд 161,568.5 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 161,130.36 мянган төгрөг буюу 99.73 хувьтай байгаа нь шуудан холбоо, интернэтийн төлбөрийн хэмнэлт, музейд зохион байгуулагдсан үзэсгэлэнгийн орлого өссөн зэргээс шалтгаалжээ.

Нэмэлт санхүүжилтийн дансаар нийт 21,500.0 мянган төгрөгийн санхүүжилт авснаас цалингийн зардалд 8,385.0 мянган төгрөг, бараа материалд 11,600.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажилд 1,500.0 мянган төгрөгийг тус тус зарцуулж 15.0 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

### **2.11 Шилэн дансны мэдээлэл**

Театрын музей Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй. Шилэн дансны цахим хуудсанд байгууллагын тухайн жилийн төсөв, гүйцэтгэл, цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлого, санхүүжилт, 2018 оны эхний хагас жилийн санхүү, төсвийн гүйцэтгэлийн тайлан зэрэг мэдээллүүдийг оруулсан байна.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

### **2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 83 хувьтай байна. Өмнөх оны аудитаар нийт 6 албан шаардлага, 1 төлбөрийн акт, 1 зөвлөмж өгсөн байна. Үүнээс 1 актын төлбөрийг бүрэн барагдуулж, 1 зөвлөмжийг хэрэгжүүлж, 6 албан шаардлагаас 5-ыг нь биелүүлсэн байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

### **2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Театрын музейн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Театрын музейн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

### **3 Менежментийн захидал**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Театрын музейн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### **3.1 ӨГЛӨГИЙН ТАЛААР**

##### **1. Илрүүлэлт:**

2018 оны санхүүгийн тайлангийн аудитын төлбөр болох 1,000.0 мянган төгрөгийг төлөөгүй боловч тайланд өглөгөөр бүртгэж тайлагнаагүй байна.

##### **2. Эрсдэл:**

Төсвийн тухай хууль зөрчигдөх эрсдэлтэй.

##### **3. Зөвлөмж:**

Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д “Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккрузл суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэснийг хэрэгжүүлэн ажиллах.

##### **4. Байгууллагын тайлбар :**

Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 6 сарын 30-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4 Аудит хийгдсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

##### 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

ТАЙЛАНТ ХУГАЦАА: 2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НЭЭР ДУУСВАР БОЛСОН ТАЙЛАН

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт   | Эхний үлдэгдэл        | Эцсийн үлдэгдэл       |
|------------|---|-----------------------|-----------------------|
| <b>1</b>   | <b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>  | <b>872,258.00</b>     | <b>16,761,302.68</b>  |
| <b>33</b>  | <b>АВЛАГА</b>   | -                     | 128,794.68            |
| <b>335</b> | <b>Бусад авлага</b>   | -                     | 128,794.68            |
| 3351       | Байгууллагаас авах авлага   | -                     | 128,794.68            |
| <b>35</b>  | <b>БАРАА МАТЕРИАЛ</b>   | 872,258.00            | 16,632,508.00         |
| 35300      | Бэлэн бүтээгдэхүүн  | -                     | 12,582,200.00         |
| <b>354</b> | <b>Хангамжийн материал</b>  | 872,258.00            | 4,050,308.00          |
| 35420      | Аж ахуйн материал   | 872,258.00            | 2,613,108.00          |
| 35470      | Бусад хангамжийн материал   | -                     | 1,437,200.00          |
| <b>2</b>   | <b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>                                    | <b>811,710,064.55</b> | <b>833,036,191.90</b> |
| <b>39</b>  | <b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>   | 811,710,064.55        | 833,036,191.90        |
| <b>392</b> | <b>Биет хөрөнгө</b>   | 811,162,704.63        | 832,557,252.02        |
| 39205      | Машин тоног төхөөрөмж (компьютер)                                     | 13,878,873.00         | 22,725,423.00         |
| 39206      | Хуримтлагдсан элэгдэл   | 5,551,548.72          | 7,581,725.00          |
| 39207      | Тавилга, аж ахуйн эд хогшил   | 43,727,018.73         | 61,177,018.73         |
| 39208      | Хуримтлагдсан элэгдэл   | 26,202,823.73         | 31,266,854.45         |
| 39213      | Түүх соёл, музейн дурсгалт зүйлс                                      | 778,669,020.00        | 779,669,020.00        |
| 39214      | Бусад үндсэн хөрөнгө  | 22,108,873.75         | 25,608,873.75         |
| 39215      | Хуримтлагдсан элэгдэл   | 16,976,708.40         | 19,284,504.01         |
| 39217      | Ном   | 1,510,000.00          | 1,510,000.00          |
| <b>393</b> | <b>Биет бус хөрөнгө</b>   | 547,359.92            | 478,939.88            |
| 39301      | Програм хангамж   | 684,200.00            | 684,200.00            |
| 39302      | Хуримтлагдсан элэгдэл   | 136,840.08            | 205,260.12            |
| <b>3</b>   | <b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>                                    | <b>812,582,322.55</b> | <b>849,797,494.58</b> |
| <b>5</b>   | <b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>                                       | <b>812,582,322.55</b> | <b>849,797,494.58</b> |
| <b>51</b>  | <b>Засгийн газрын хувь оролцоо</b>                                    | 812,582,322.55        | 849,797,494.58        |
| 511        | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 70,433,859.73         | 70,433,859.73         |
| 51101      | Өмч: - төрийн   | 70,433,859.73         | 70,433,859.73         |
| <b>512</b> | <b>Хуримтлагдсан үр дүн</b>   | 21,428,529.82         | 58,643,701.85         |
| 51210      | Өмнөх үеийн үр дүн  | 21,428,529.82         | 41,878,529.82         |
| 51220      | Тайлант үеийн үр дүн  | -                     | 16,765,172.03         |
| 51300      | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү                                      | 720,719,933.00        | 720,719,933.00        |
| <b>6</b>   | <b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>                    | <b>812,582,322.55</b> | <b>849,797,494.58</b> |

## 4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

ТАЙЛАНТ ХУГАЦАА: 2018 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НЭЭР ДУУСВАР БОЛСОН ТАЙЛАН

| Дансны код  | Үзүүлэлт  | Өмнөх оны гүйцэтгэл   | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|---|-----------------------|-----------------------|
| <b>1</b>    | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>  | <b>188,423,189.75</b> | <b>195,453,900.00</b> |
| <b>12</b>   | <b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>  | <b>5,547,889.75</b>   | <b>14,543,400.00</b>  |
| <b>120</b>  | <b>Нийтлэг татварын бус орлого</b>  | 5,547,889.75          | 14,543,400.00         |
| 120004      | Төсөв байгууллагын өөрийн орлого  | 5,547,889.75          | 13,681,400.00         |
| 1200041     | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих   | 2,158,000.00          |                       |
| 1200042     | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих   | -                     | 2,203,500.00          |
| 1200045     | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого   | 3,389,889.75          | 11,477,900.00         |
| 120009      | Бусад орлого  | -                     | 862,000.00            |
| <b>13</b>   | <b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>  | <b>182,875,300.00</b> | <b>180,910,500.00</b> |
| <b>1310</b> | <b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>  | 150,525,300.00        | 159,410,500.00        |
| 131001      | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт   | 150,525,300.00        | 159,410,500.00        |
| <b>1311</b> | <b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>  | 32,350,000.00         | 21,500,000.00         |
| 131104      | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн 4захирагчид хуваарилсан хөрөнгө | 32,350,000.00         | 21,500,000.00         |
| <b>2</b>    | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>  | <b>188,599,835.66</b> | <b>178,688,727.97</b> |
| <b>21</b>   | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>  | <b>188,599,835.66</b> | <b>178,688,727.97</b> |
| <b>210</b>  | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>  | 171,151,335.66        | 178,190,089.23        |
| <b>2101</b> | <b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>  | 96,546,373.00         | 106,208,799.00        |
| 210101      | Үндсэн цалин  | 86,583,500.00         | 79,464,299.00         |
| 210102      | Нэмэгдэл  | -                     | 14,144,500.00         |
| 210103      | Унаа хоолны хөнгөлөлт   | 5,365,100.00          | 12,600,000.00         |
| 210105      | Гэрээт ажлын хөлс   | 4,597,773.00          |                       |
| <b>2102</b> | <b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>   | 10,949,800.00         | 13,160,667.78         |
| 210201      | Тэтгэврийн даатгал  | 6,968,055.00          | 9,192,267.78          |
| 210202      | Тэтгэмжийн даатгал  | 995,436.00            | 992,200.00            |
| 210203      | ҮОМШӨ-ний даатгал   | 796,350.00            | 793,200.00            |
| 210204      | Ажилгүйдлийн даатгал  | 199,087.00            | 198,500.00            |
| 210205      | Эрүүл мэндийн даатгал   | 1,990,872.00          | 1,984,500.00          |
| <b>2103</b> | <b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>  | 20,978,400.00         | 30,978,600.00         |
| 210304      | Байрны түрээс   | 20,978,400.00         | 30,978,600.00         |
| <b>2104</b> | <b>Хангамж, бараа материалын зардал</b>   | 1,684,200.00          | 5,858,099.80          |
| 210401      | Бичиг хэрэг   | 131,800.00            | 2,511,110.00          |
| 210403      | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр  | 896,000.00            | 977,139.80            |
| 210404      | Ном, хэвлэл   | -                     | 129,800.00            |
| 210405      | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал   | -                     | 450,500.00            |
| 210406      | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс   | 656,400.00            | 1,789,550.00          |
| <b>2105</b> | <b>Нормативт зардал</b>   | 247,500.00            | -                     |

Театрын музейн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд  
